

**ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ АВИЛГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2014 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2014 оны 11 сарын 10

1. Хуулиар хүлээсэн үүргийн биелэлт						
№	Хийх ажлын агуулга	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэл	Оноо 0-70	
					Авбал зохих	Авсан
1.	Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо, нөхцлөөр хангах	1/ Хууль бусад шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, ТББ-ын саналыг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-аар дамжуулан мөн цаасаар, хэлэлцүүлэг зохион байгуулах замаар зэрэг ямар нэгэн хэлбэрээр хүлээн авч, тусгасан байх.	Хууль бусад шийдвэрийн төслүүдийг иргэд, олон нийтээр хэлэлцүүлсэн байна. Зөв, зүйтэй саналыг тусгасан байна.	Хууль болон бодлогын баримт бичгүүдийн төслийг ҮХААЯ-ны цахим хуудас www.mofa.gov.mn -аар дамжуулан олон нийтээр тогтмол хэлэлцүүлж байна. Мөн олон нийтийн санал, асуулгыг цаасаар авч Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлж, төсөлд тусгах нь зүйтэй гэж, үзсэн саналыг баримт бичгийн төсөлд тусган эцэслэн боловсруулж байна. <i>/Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэхэд шаардагдах баримт бичгийн 5-рт 92 хуудас зарим нотлох баримтыг хавсаргасан./</i>	0-3	3
2.	Авилгалын эсрэг соён гэгээрүүлэх, авилгатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх	1/ Авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг, холбогдох нотлох баримтын хамт Авилгатай тэмцэх газарт хүргүүлэх.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, нотлох баримтын хамт АТГ-т хүргүүлсэн байна.	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг АТГ-аас ирүүлсэн аргачлалын дагуу боловсруулж, АТГ-аас санал авч, 2014 оны 2 сарын 5-ны өдөр ТНБД-аар батлуулан, 2014 оны 2 сарын 6-ны өдрийн 03/430 тоот албан бичгээр Авлигатай тэмцэх газар хүргүүлсэн. Авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, биелэлтийг нотлох баримтын хамт 2014 оны 11 сарын 14-нд Авлигатай тэмцэх газар хүргүүлэв.	0-5	5

		2/ Авлигын эсрэг арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг төлөвлөж, зохион байгуулах.	Авлигын эсрэг арга хэмжээг санхүүжүүлж, зохион байгуулсан байна.	ҮХААЯ-ны хөтөлбөр, төслийн дотоод урсгал зардлын 2014 оны төсөвт Авлигын эсрэг арга хэмжээний зардалд 1,850,000 төгрөг тусгасан. 2014 онд аль болох зардлыг хэмнэх үүднээс аливаа зөвлөмж, зөвлөгөөг биечлэн өгч, гарын авлага, хууль таниулах сурталчилгааг яамны дотоод цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах, өөрийн боломжоор гарын авлага хэвлэх олшруулах замаар ажиллаж энэхүү төлөвлөгөөний заалт бүрийг бүрэн хэрэгжүүлэхэд идэвх санаачлагатай ажиллаа. <i>/Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэхэд шаардагдах баримт бичгийн 38-рт 1 хуудас зарим нотлох баримтыг хавсаргасан./</i>		
3.	Авилгын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах	1/ Авилгын эсрэг хууль тогтоомж, мэдээлэл, Авилгатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг яамны 1 дүгээр давхарт, ил харагдахуйц байрлалд Авилгын эсрэг үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн самбарт байрлуулах мөн яамны дотоод мэдээллийн “ASU” сүлжээгээр дамжуулан сурталчлах.	Авилгын эсрэг үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг, боломжит хэлбэрээр сурталчилсан байна.	- ҮХААЯ-ны цахим хуудаст www.mofa.gov.mn “Авлигын эсрэг үйл ажиллагаа, ХАСХОМ” булан нээж, холбогдох хууль тогтоомж, маягт, зөвлөмжүүдийг байршуулав. - АТГ-аас гаргасан “Нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлага”, “Мэдүүлэг гаргагч нарт зориулсан гарын авлага”-ыг ҮХААЯ-ны дотоод сүлжээнд байршуулсан. - Яамны 1 дүгээр давхарт, орох хаалганы хажууд ил харагдахуйц байрлалд Авилгын эсрэг үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн самбар байрлуулж, Авилгын эсрэг хууль тогтоомж, Авилгатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, мэдээлэл, сурталчилгааны материалыг тогтмол сурталчилан ажиллаж байна. <i>/Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэхэд шаардагдах баримт бичгийн 1, 2-рт нийт 7 хуудас зарим нотлох баримтыг хавсаргасан./</i>	0-2	2

4.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох	1/ Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч тусгах.	Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг бүрийг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т байршуулсан байна. Зөв, зүйтэй саналыг тусгасан байна.	Бодлогын баримт бичгүүдийн төслийг ҮХААЯ-ны цахим хуудас www.mofa.gov.mn -аар дамжуулан олон нийтээр тогтмол хэлэлцүүлж байна. Мөн олон нийтийн санал, асуулгыг цаасаар авч Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлж, төсөлд тусгах нь зүйтэй гэж, үзсэн саналыг баримт бичгийн төсөлд тусган эцэслэн боловсруулж байна. /Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэхэд шаардагдах баримт бичгийн 5-рт 92 хуудас зарим нотлох баримтыг хавсаргасан./	0-3	3
5.	Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах	1/ Яам болон харьяа байгууллагад дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөөг батлуулах.	Төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулсан байна.	ҮХААЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас гүйцэтгэлийн дотоод аудитын 2014 оны үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг 2014 оны хагас жилийн байдлаар гаргаж мэдээлсэн. /14 хуудас нотлох баримтыг хавсаргав./	0-3	3
		2/ Хийсэн дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т байршуулах.	Дүнг олон нийтэд мэдээлсэн байна.	“Журам батлах тухай” Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын 1-р хавсралтад заасан хугацаанд бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг ЗГХЭГ-т хүргүүлж, яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т байршуулж байна. 2014 онд хийсэн гүйцэтгэлийн дотоод аудитын дүгнэлт, зөвлөмжийг тухайн байгууллага, яамны газар, хэлтэст танилцуулан, хүргүүлж байна. /2 хуудас нотлох баримтыг хавсаргав./		
		3/ Хийсэн дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний дагуу дүгнэлт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажиллах.	Дүгнэлт, зөвлөмж гаргаж, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.	ҮХААЯ-ны хүний нөөцийн асуудалд хийсэн дотоод аудитын зөвлөмжийн дагуу дор дурдсан ажлуудыг хэрэгжүүлээд байна. - ТНБД-ын 2014 оны Б/121 тоот тушаалаар Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн албан хаагчдын орон тоог цомхотгож, шинэчлэн баталсантай холбогдуулан 7 албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулж батлуулсан.		

				<p>- Төрийн албан хаагчдын 2014 онд байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг хагас жилээр дүгнэж, үүргээ хангалтгүй биелүүлсэн 3 албан хаагчдад ТНБД-ын 2014 оны Б/109, 121 тоот тушаалаар сахилгын шийтгэл ноогдуулав.</p> <p>- Мэдээллийн цаг зохион байгуулах тухай ТНБД-ын 2014 оны А/384 тоот тушаалыг гаргаж, эхний мэдээллийг СБТГ-аас 10 сарын 31-ний өдөр амжилттай зохион байгуулав.</p> <p><i>/8 хуудас нотлох баримтыг хавсаргав./</i></p>		
6.	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх	1/ 2014 оны төсөв, 2013 оны төсвийн гүйцэтгэл, 2015 оны төсвийн төслийг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т байршуулах.	2014 оны төсвийг 1 сарын 10-ны дотор, 2013 оны төсвийн гүйцэтгэлийг 4 сарын 1-ний дотор, 2015 оны жилийн төсвийн төслийг 8 сарын 15-ны дотор цахим хуудас/www.mofa.gov.mn/-т байршуулсан байна.	Үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарын 2014 оны төсөв, төсвийн хуваарь, 2013 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т байршуулав. 2015 оны төсвийн төслийг боловсруулж, Сангийн яаманд 2014 оны 8 сарын 15-ны өдөр хүргүүлсэн бөгөөд хууль батлагдахаар цахим хуудаст байршуулна.	0-8	8
		2/ 2014 оны санхүүгийн тайланг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/, мэдээллийн самбарт байршуулах.	Цахим хуудаст болон мэдээллийн самбарт хугацаанд нь байршуулсан байна.	Үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарын болон яамны 2014 оны төсвийн гүйцэтгэлийг сар бүр яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/, мэдээллийн самбарт байршуулж 6-р давхарт байршуулсан дэлгэцээр тогтмол мэдээлж байна.		
		3/ 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/, мэдээллийн самбарт байршуулах.	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг цахим хуудаст болон мэдээллийн самбарт хугацаанд нь байршуулсан байна.	Үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарын 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/, мэдээллийн самбарт байршуулж мэдээлсэн.		
		4/ Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт болон татварын орлого, татварын бус орлогын талаархи мэдээллийг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/,	Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаархи мэдээллийг өөрчлөлт орсноос хойш ажлын 14	Үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарын 2014 оны тодотгосон төсвийг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/, мэдээллийн самбарт хуулийн хугацаанд нь байршуулж мэдээлсэн.		

		мэдээллийн самбарт байршуулах.	хоногт багтаан нийтэд мэдээлсэн байна.			
		5/ Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг хуулийн хугацаанд яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т байршуулах.	Нэрсийн жагсаалтыг хуулийн хугацаанд цахим хуудаст байршуулсан байна.	ҮХААЯ-наас 2014 онд 3 албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарч, олгосон нэг удаагийн буцалтгүй тусламжийн мэдээг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т байршуулсан.		
		6/ Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаархи мэдээллийг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т байршуулах.	Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаархи мэдээллийг цахим хуудсанд байршуулсан байна.	ҮХААЯ-наас гадаадын зээл тусламжаар 16 төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаа бөгөөд жагсаалтыг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т байршуулсан. <i>/9 хуудас нотлох баримтыг хавсаргав./</i>		
7.	Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах	1/ Яамнаас олгож буй тусгай зөвшөөрөл, лиценз, түүнийг олгоход шаардлагатай бичиг баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т байршуулах.	Мэдээллийг цахим хуудаст ойлгомжтой байдлаар байршуулсан байна.	ҮХААЯ-наас олгож байгаа аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, журмыг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т байршуулсан. <i>/3 хуудас нотлох баримтыг хавсаргав./</i>	0-3	3
		2/ Тусгай зөвшөөрөл, лиценз эзэмшигчийн нэр хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т байршуулж, шинэчлэж байх.	Мэдээллийг цахим хуудаст байршуулж, тухай бүр шинэчлэсэн байна.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл шинээр авсан, хугацаа сунгуулсан иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг 2014 оны 11 сарын 01-ний өдрийн байдлаар шинэчлэн гаргаж, яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т байршуулсан. <i>/Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэхэд шаардагдах баримт бичгийн 12-рт 10 хуудас зарим нотлох баримтыг хавсаргасан./</i>		
8.	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах	1/ Төрийн албаны салбар зөвлөлийн эрх хэмжээний хүрээнд явагдах сул орон тооны сонгон шалгаруулалтын зарыг өдөр тутмын сонин	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байна.	Сонгон шалгаруулалтын зарыг ҮХААЯ-ны цахим хуудаст www.mofa.gov.mn байршуулдаг бөгөөд 2014 онд сонгон шалгаруулалт зарлаагүй. 2014 онд төрийн захиргааны 27 албан	0-4	3

		болон нь яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/, мэдээллийн самбарт байршуулах.		хаагчийг шинээр томилж, үүнээс 11 сарын 10-ны байдлаар 18 албан хаагч ажиллаж байна. Төрийн албан хаагчийн мэргэшлийн шалгалтад тэнцэж Төрийн албаны зөвлөлийн нөөцөд байсан 12 иргэнийг 2014 онд тус яаманд төрийн захиргааны албан хаагчаар томилон ажиллуулж байна. <i>/Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэхэд шаардагдах баримт бичгийн 15-рт 35 хуудас зарим нотлох баримтыг хавсаргасан./</i>		
		2/ Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг боловсруулж, яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т байршуулах.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудаст ойлгомжтой байдлаар байршуулсан байна.	Яамны “Хүний нөөцийн стратегийн төлөвлөлт” (2014-2016)-ийн баримт бичиг боловсруулах ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны А/396 дугаар тушаалаар баталсан. Ажлын хэсэг баримт бичгийн төслийг боловсруулсан бөгөөд 2014 онд багтаан эцэслэн боловсруулж, батлуулахаар ажиллаж байна.		
		3/ Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаархи мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй байлгаж, яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/, мэдээллийн самбарт байршуулах.	Мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байна.	ҮХААЯ-ны цахим /www.mofa.gov.mn/ хуудаст “Хүний нөөц” булан ажиллуулж, холбогдох мэдээллийг байршуулан, хүний нөөцийн талаар авч байгаа шийдвэрийн хуулбар, дотоод зарлал, мэдээллийг тусгай самбар гарган тухай бүр хэрэглэгчдэд түгээж байна. <i>/3 хуудас нотлох баримтыг хавсаргав./</i>		
		4/ Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн гэрээг үнэлэх загвар, журмыг цахим хуудсанд байршуулах.	Загвар, журмыг цахим хуудаст байршуулсан байна.	Төрийн захиргааны албан хаагчийн Үр дүнгийн гэрээний биелэлтийг илтгэх, үнэлж дүгнэх журмыг Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны А/07 дугаар тушаалаар баталж мөрдөж ажиллаж байна. Журмыг яамны цахим /www.mofa.gov.mn/ хуудаст байршуулж ажлын гүйцэтгэлийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.		
9.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,	1/ Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим	2014 онд Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний ерөнхий төлөвлөгөөг ҮХАА-н сайдын 2013 оны А/165 тоот тушаалаар	0-10	10

<p>үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах</p>	байршуулах.	хуудаст байршуулсан байна.	батлуулж, яамны цахим /www.mofa.gov.mn/ хуудаст болон худалдан авах ажиллагааны www.e-procurement.mn цахим хуудаст цаг хугацаанд нь байрлуулсан болно. <i>/11 хуудас нотлох баримтыг хавсаргав./</i>
	2/ Тендерийн шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/, мэдээллийн самбарт байршуулах.	Тендерийн шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудас болон мэдээллийн самбарт тухай бүр байршуулсан байна.	Тендер шалгаруулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд зохион байгуулж байгаа бөгөөд 2014 онд зарлагдсан тендер, төсөл сонгон шалгаруулах 77 удаагийн урилгыг яамны цахим www.mofa.gov.mn хуудас, худалдан авах ажиллагааны www.e-procurement.mn цахим хуудаст байршуулж мэдээлсэн. Яамны Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах самбарт урилгыг тухай бүр байршуулсан. <i>/Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэхэд шаардагдах баримт бичгийн 17-рт 68 хуудас зарим нотлох баримтыг хавсаргасан./</i>
	3/ Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонингоор дамжуулан нийтэд зарласан байх.	Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын 2-оос доошгүй сонингоор дамжуулан нийтэд зарласан байна.	Тендерийн урилга бүрийг үндэсний хэмжээний өдөр тутмын 2 сонингоор дамжуулан нийтэд зарласан. <i>/Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэхэд шаардагдах баримт бичгийн 17-рт 65 хуудас зарим нотлох баримтыг хавсаргасан./</i>
	4/ Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаархи мэдээлэл болон шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т, байршуулах.	Тендерт шалгарсан болон шалгараагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар иргэдэд мэдээлсэн байна.	2014 оны 10 сарын 15-ны байдлаар 54 худалдан авах ажиллагааг зохион байгуулж, шалгаруулалтын талаарх ил тод байдлын мэдээллийг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т, байршуулсан. <i>/8 хуудас нотлох баримтыг хавсаргав./</i>
	5/ Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т байршуулах.	Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайлан иргэдэд нээлттэй байна.	

		6/ Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлэх.	Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлсэн байна.	2014 оны тендер шалгаруулалтын явцад ямар нэгэн зөрчил илэрээгүй.		
		7/ Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т байршуулах.	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүн иргэдэд нээлттэй байна.	МУ-ын Ерөнхий аудиторын 2014 оны 4 сарын 25-ны 697 тоот албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг яамны www.mofa.gov.mn цахим хуудас байршуулсан. Өөр аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг тус яаманд ирүүлээгүй.		
		8/ Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, Төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байна.	Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, Төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байна.	2014 онд байгуулсан бүх үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, Төрийн бус байгууллагын төлөөллийг бүрэн оролцуулсан. <i>/Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэхэд шаардагдах баримт бичгийн 16-рт 13 хуудас нотлох баримтыг хавсаргасан./</i>		
10.	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох	1/ Төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлсэн байх.	Төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлсэн байна.	Албан хаагчийн ажлын байр шинээр нэмэгдсэн эсвэл өөрчлөлт /ажлын байрыг нэгтгэх, цомхотгох.../ орсон тохиолдолд Хүний нөөцийн мэргэжилтэн, тухайн газрын даргатай хамтран тухай бүр өөрчлөлтийг хийж, Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод газрын дарга, ТНБД нар гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулж байна. - ТНБД-ын 2014 оны Б/121 тоот тушаалаар Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн албан хаагчдын орон тоог цомхотгож, шинэчлэн баталсантай холбогдуулан 7 албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулж батлуулсан. - Мөн ТЕГ-ын 2014 оны 01/1557 тоот албан бичгээр төрийн нууц хариуцсан ажилтны	0-2	2

				<p>ажлын байрны нийтлэг тодорхойлолтыг ирүүлж, хэрэгжүүлэхийг зөвлөмж болгосны дагуу Төрийн захиргааны удирдлагын газрын нууц, дайчилгаа, авлигын эсрэг асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлуулсан.</p> <p>- 2014 оны 7 сард яамны хүний нөөцийн асуудалд дотоод аудит хийж, албан хаагч нэг бүрийн ажлын байрны тодорхойлолтыг хянаж, дүгнэлт, зөвлөмж гаргасан.</p> <p><i>/Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэхэд шаардагдах баримт бичгийн 19-рт 5 хуудас, 23-рт 4 хуудас нотлох баримтыг хавсаргасан./</i></p>		
		2/ Төрийн албан хаагч нэг бүрийн хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/, самбарт байршуулах.	Мэдээллийг цахим хуудаст болон яамны 1 давхарт нэгдсэн самбар байршуулсан байна.	<p>Яамны бүх төрийн захиргааны албан хаагчдын нэр, албан тушаал, холбоо барих утасны жагсаалтыг яамны www.mofa.gov.mn цахим хуудаст байршуулсан.</p> <p>2014 онд яамны 1-р давхарт газар, хэлтсийн ажилтнуудын өрөөний дугаар, утасны дугаарыг ил тод ойлгомжтой байдлаар харуулсан самбар шинээр хийж байршууллаа.</p> <p><i>/5 хуудас нотлох баримтыг хавсаргав./</i></p>		
11.	Авигатай тэмцэх зориго бүхий Төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах	1/ Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажиллаж, зарим чиг үүргийг гүйцэтгүүлж, мэдээ, тайланг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т байршуулах.	Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран үйл ажиллагаа хэрэгжүүлж, тайлан, үр дүнг мэдээлсэн байна.	<p>2014 оны 11 сарын 10-ны байдлаар нийт 30 ажил, үйлчилгээг Төрийн бус байгууллага, салбарын мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлээд байна.</p> <p>Тайлан мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж, ЗГХЭГ-т мэдээлж байна.</p> <p><i>/Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэхэд шаардагдах баримт бичгийн 20-рт 61 хуудас зарим нотлох баримтыг хавсаргасан./</i></p>	0-2	2
		2/ Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх.	Иргэний нийгмийн оролцоог дэмжиж, хамтран ажилласан байна.	<p>ҮХААЯ-ны үйл ажиллагааг ил тод байлгаж, иргэд, аж ахуйн нэгж, салбарын мэргэжлийн холбоод, ТББ-ыг татан оролцуулж, төрийн зарим ажил, үйлчилгээг гүйцэтгүүлж хэвшээд байна.</p> <p>Махны нөөцийн бүрдүүлэлт, борлуулалт, тариаланчдын төмс, хүнсний ногоо</p>		

				<p>борлуулахад дэмжлэг үзүүлэх, малчдад ноос, ноолуурын урамшуулал олгох зэрэг боломжит бүхий л үйл ажиллагаандаа тэднийг татан оролцуулж байна.</p> <p>Жишээ нь: 2014 оны өвөл, хаврын улиралд хүн амын хэрэгцээнд нийлүүлсэн нөөцийн махны борлуулалтад ТББ, аймаг нийслэлийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдээс хяналт тавин ажиллаж, илэрсэн зөрчил, дутагдлыг газар дээр нь арилгуулан, тайлан, мэдээг тухай бүр хүлээн авч ажиллаа.</p> <p><i>/43 хуудас нотлох баримтыг хавсаргав./</i></p>		
12.	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх</p>	<p>1/ Эрх бүхий албан тушаалтныг томилон ажилуулсан байх.</p>	<p>Эрх бүхий албан тушаалтныг томилсон байна.</p>	<p>ТНБД-ын 2013 оны Б/136 дугаар тушаалаар Авлига, ашиг сонирхлын зөрчил, дайчилгаа, нууцын асуудал хариуцсан мэргэжилтнээр Г. Наранцэцэгийг томилон ажиллуулж байна.</p> <p><i>/Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэхэд шаардагдах баримт бичгийн 22-рт 1 хуудас зарим нотлох баримтыг хавсаргасан./</i></p>	0-3	3
		<p>2/ Гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгах.</p>	<p>Гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгасан байна.</p>	<p>ТЕГ-ын 2014 оны 01/1557 тоот албан бичгээр төрийн нууц хариуцсан ажилтны ажлын байрны нийтлэг тодорхойлолтыг ирүүлж, хэрэгжүүлэхийг зөвлөмж болгосны дагуу Төрийн захиргааны удирдлагын газрын нууц, дайчилгаа, авлигын эсрэг асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод саналыг тусган шинэчлэн боловсруулж, 2014 оны 5 сарын 01-ний өдөр ТЗУГ-ын дарга, ТНБД-аар батлуулан мөрдөж ажиллаж байна.</p> <p><i>/Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэхэд шаардагдах баримт бичгийн 23-рт 4 хуудас зарим нотлох баримтыг хавсаргасан./</i></p>		
		<p>3/ Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтанд хамрагдах.</p>	<p>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтанд хамрагдсан байна.</p>	<p>- АТГ-аас 2014 оны 01 дүгээр сарын 09-нд ҮХААЯ-ны албан хаагчдын дунд зохион байгуулсан "ХАСХОМ мэдүүлэгч нарт зориулсан сургалт",</p> <p>- АТГ, "Нийгмийн дэвшлийн эмэгтэйчүүд"</p>		

			<p>хөдөлгөөнтэй хамтран 02 дугаар сарын 07-ны өдөр ҮХААЯ-ны албан хаагчдын дунд зохион байгуулсан “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах” сургалт</p> <p>- АТГ-аас 2014 оны 04 сарын 24-нд зохион байгуулсан “ЭБАТ-тай ярилцах цаг” сургалт,</p> <p>- АТГ-аас 2014 оны 10 сарын 31-ний өдөр ҮХААЯ-ны албан хаагчдын дунд зохион байгуулсан “Авлигын эсрэг хууль таниулах” сургалтад тус тус хамрагдсан.</p>	
	4/ Хувь хүний нууцтай холбогдох мэдээлэл, ХАСХОМ-ийг цоожтой шүүгээнд тусгайлан хадгалж, мэдээллийн хамгаалалтын баталгааг хангасан байна.	Хувь хүний нууцтай холбогдох мэдээллийг цоожтой тусгай шүүгээнд хадгалж, хамгаалсан байна.	<p>Эрх бүхий албан тушаалтан хариуцан Албан хаагчдын ХАСХОМ-ын мэдүүлгийг цоожтой, лацтай, төмөр шүүгээнд холбогдох мэдээллээр ангилан хийж, хадгалан мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.</p> <p><i>/1 хуудас нотлох баримтыг хавсаргав./</i></p>	
	5/ Эрх бүхий албан тушаалтан хууль, журамд заасан үүргийг хэрэгжүүлэх.	Хууль, журамд нийцүүлэн ажил, үүргээ гүйцэтгэсэн байна.	<p>Хууль, журамд заасны Эрх бүхий албан тушаалтан дагуу дор дурдсан ажлуудыг гүйцэтгээд байна. Үүнд:</p> <p>- 2013 оны мэдүүлэг гаргагчдын нэрсийн жагсаалтыг 2014 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр Авлигатай тэмцэх газар хүргүүлэв.</p> <p>- 2013 оны мэдүүлэг гаргавал зохих нийт 107 төрийн албан хаагчдыг бүрэн хамруулан, мэдүүлгийг хуулийн хугацаанд цаасаар болон цахимаар хүлээн авч, бүртгэл хөтлөн мэдүүлгийн тайланг ХАСХОМ-1, 2, 3, 4 маягтаар гаргаж, 2014 оны 2 дугаар сарын өдөр 19-ний өдөр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.</p> <p>- 2014 оны тайлангийн бүртгэлийг цаг хугацаанд нь хөтөлж цаасаар ирүүлсэн 141 мэдүүлэг, 189 удаагийн мэдэгдэл, 22 урьдчилсан мэдүүлэг хүлээн авч, бүртгэл хөтлөн, мэдүүлгийн бүрдүүлэлтийн программд оруулж байна.</p> <p>- Яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т “Авлигын эсрэг ХАСХОМ” булан, дотоод сүлжээгээр дамжуулж хууль тогтоомж таниулах, гарын авлага хүргүүлэх ажлыг</p>	

					<p>зохион байгуулж байна.</p> <p>- Давхар ажил эрхлэлтийн судалгааг авч, тухай бүр өөрчлөлтийг хийж байна.</p> <p>- Мэдүүлэг гаргагчдад яамны дотоод сүлжээгээр болон өөрийн биеэр заавар, зөвлөгөө тогтмол өгч ажиллаж байна.</p> <p><i>/20 хуудас нотлох баримтыг хавсаргав./</i></p>			
13.	Ашиг зөрчлөөс сэргийлэх дүрмийг мөрдүүлэх	сонирхлын урьдчилан ёс зүйн тогтоон	1/ Ёс зүйн дүрмийг цахим /www.mofa.gov.mn/-т дотоод мэдээллийн сүлжээнд байршуулах.	яамны хуудас болон “ASU”	Ёс зүйн дүрмийг цахим хуудас болон дотоод сүлжээнд байршуулсан байна.	<p>- ҮХААЯ-ны ТНБД-ын 2013 оны А/132 дугаар тушаалаар Ёс зүйн хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна.</p> <p>- Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм батлах тухай Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоол, ТАЗ-ийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам” –ыг тус тус үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаж байна.</p> <p>- Яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т “Хүний нөөц” буланд Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн тухай зөвлөмж, хичээл, сургалтын материалыг байрлуулснаар ёс зүйн тухай ойлголт, мэдээлэл авах боломж нөхцлөөр хангалаа.</p> <p>- Өөрийн нөөц бололцоогоо ашиглаж ёс зүйн дүрэм, журмыг хэвлэн, олшруулж шинээр ажилд орж байгаа албан хаагчдад тарааж байна. Ёс зүйн дүрмийг дотоод сүлжээнд байршуулсан.</p> <p><i>/3 хуудас нотлох баримтыг хавсаргав./</i></p>	0-5	5
			2/ Зөрчлийн талаархи мэдээлэл хүлээн авах буланг цахим /www.mofa.gov.mn/-т ажиллуулах.	яамны хуудас нээн	Зөрчлийн талаархи мэдээлэл хүлээн авах буланг цахим хуудсанд нээн ажиллуулсан байна.	<p>- Яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т “Хүний нөөц” буланд иргэдээс Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагын талаар санал хүсэлт авах буланг ажиллуулж байна.</p>		
			3/ Зөрчлийн талаархи бүртгэл хөтлөх.		Зөрчлийн талаархи бүртгэл хөтөлсөн байна.	Зөрчлийн талаархи бүртгэлийн дэвтэр хөтөлдөг бөгөөд 2014 онд ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй.		

		4/ Зөрчлийг журамд заасан хугацаанд хянан шийдвэрлэх.	Зөрчлийг хянан шийдвэрлэсэн байна.	2014 онд ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй. Хэвийн ажиллаж байна.		
		5/ Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолодолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ /зөвлөмж/-г авах.	Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолодолд урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан байна.	- ТНБД-ын 2014 оны А/59 тоот тушаалаар “ҮХААЯ-ны дотоод журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулав. - Яамны албан хаагчдад хүний нөөцийн асуудлаар тусгай самбар байршуулж, ажлын цаг ашиглалтыг сайжруулах зоригоор ирцын бүртгэлийн цахим төхөөрөмж сурилуулан 7 хоног бүр мэдээг яамны шуурхай хуралдаанд газар, хэлтсийн дарга нарт мэдээлж ажиллаж байна. - ТНБД-ын 2014 оны А/384 тоот шийдвэрээр албан хаагчдын дунд сар бүр “Мэдээллийн цаг” зохион байгуулж байна. <i>/5 хуудас нотлох баримтыг хавсаргав./</i>		
		6/ Зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэх.	Зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэсэн байна.	Одоогоор ёс зүйн зөрчил илрээгүй байна.		
		7/ Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг дотоод мэдээллийн “ASU” сүлжээгээр дамжуулан мэдээлсэн байх.	Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг мэдээлсэн байна.	Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн талаар цахим хуудсаар дамжуулан нээлттэй мэдээлэл өгч ажиллаж байгаа.		
		8/ Тайлан, мэдээг АТГ-т хуулийн хугацаанд хүргүүлэх.	Тайлан, мэдээг АТГ-т хүргүүлсэн байна.	ХАСХОМ-ын тайланг 2014 оны 2 дугаар сарын 19-ний өдөр, Авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг 2014 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр тус тус хуулийн хугацаанд нь хүргүүлсэн.		
14.	Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх.	1/ Хуулиар болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, дотоод мэдээллийн “ASU” сүлжээгээр дамжуулан танилцуулсан байх.	Давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг албан хаагчдад танилцуулсан байна.	Давхар ажил эрхлэлтийн судалгааг авч, нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр хийж 2014 оны 11 сарын 10-ны өдрийн байдлаар шинэчлэн ажиллагсад танилцуулахаар яамны дотоод сүлжээний файлын санд байршуулсан. Өөрийн нөөц болоцоог ашиглаж давхар ажил эрхлэлтийн талаар жижиг гарын авлага болгон хэвлэж, шинээр орж байгаа албан хаагчдад өгч байна.	0-2	2

		2/ Албан тушаалтанд давхар ажил эрхлэх зөвшөөрөл, давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хуулийн дагуу хэрэгжүүлэх.	Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хуулийн дагуу хэрэгжүүлсэн байна.	Яамны албан хаагчдаас давхар ажил эрхлэлтийн судалгаа авч, нэмэлт өөрчлөлтийг тухай бүр хийж байна. 11 сарын 10-ны байдлаар 18 албан хаагч хуулиар зөвшөөрсөн давхар ажил эрхэлж байгааг мэдэгдээд байна. Одоогоор хуулиар хориглосон буюу давхар ажил эрхлэлтийн талаар тайлбар, мэдэгдэл ирээгүй байна.		
15.	Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах.	1/ Эрх бүхий албан тушаалтнаас гаргаж буй төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэрийг яамны мэдээллийн самбарт тухай бүр байршуулах.	Шийдвэрийн талаархи мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж, мэдээллийн самбарт байршуулсан байна.	2014 онд батлагдсан ҮХАА-н сайдын болон ТНБД-ын тушаалын хуулбарыг яамны дотоод сүлжээнд байршуулж, мөн ҮХАА-н сайдын тушаалаар батлагдсан нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг яамны цахим хуудаст байршуулсан. Мөн аливаа тушаалын хуулбар хувийг иргэдэд үнэ төлбөргүйгээр “хуулбар үнэн” тэмдгээр баталгаажуулж олгодог. Яамны дотоод ажилтай холбоотой шийдвэрийг хүний нөөцийн мэдээллийн самбарт байршуулж байна.	0-3	3
		2/ Яамны үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, зааврыг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т болон дотоод мэдээллийн “ASU” сүлжээнд байршуулах.	Хууль тогтоомж, дүрэм журам, зааврыг яамны цахим хуудас болон дотоод мэдээллийн сүлжээнд байршуулсан байна.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журмыг яамны цахим хуудас болон яамны дотоод сүлжээнд байршуулсан. <i>/Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэхэд шаардагдах баримт бичгийн 4-рт 4 хуудас, 29-т 6 хуудас нотлох баримтыг хавсаргасан./</i>		
		3/ Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний үнэ төлсөн аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т байршуулах.	Жагсаалтыг яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т байршуулсан байна.	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний үнийг холбогдох хуулийн хүрээнд авч байна. Өөр бусад зориулалтаар ямар нэгэн төлбөр, хураамж аваагүй. <i>/Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэхэд шаардагдах баримт бичгийн 30-рт 4 хуудас нотлох баримтыг хавсаргасан./</i>		
16.	Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаархи	1/ Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрх асуудлын хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд	Үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилсан байна.	2014 онд байгууллагын үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон яамны цахим хуудсаар тогтмол дамжуулж, нийтэд мэдээлж, сурталчилж ажиллаж байна. <i>/Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг</i>	0-3	3

мэдээллийг хүлээн авч шалгах.	мэдээлж, сурталчилах.		<i>үнэлэхэд шаардагдах баримт бичгийн 34-рт 81 хуудас нотлох зарим баримтыг хавсаргасан./</i>
	2/ Өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах буланг яамны цахим хуудас / www.mofa.gov.mn /-т ажиллуулж, хариуг хүргүүлэх.	Цахим хуудаст булан нээж ажиллуулж, хариуг мэдээлсэн байна.	- ҮХААЯ-ны цахим www.mofa.gov.mn хуудаст “Өргөдөл, гомдол” булан нээж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, өргөдөл, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтийн мэдээг байршуулан олон нийтэд мэдээлж байна. <i>/Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэхэд шаардагдах баримт бичгийн 32-рт 6 хуудас нотлох зарим баримтыг хавсаргасан./</i>
	3/ 11-11 утсаар ирсэн санал хүсэлт, өргөдөлд хариу илгээх, яаманд биеэр ирж өгөх санал хүсэлтийг хүлээн авах ажилтан болон бичиг хэргийн ажилтны өрөө, утасны дугаар зэрэг мэдээллийг яамны цахим хуудас / www.mofa.gov.mn /-т болон мэдээллийн самбарт байршуулах.	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан ажилтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, харилцах утасыг цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байршуулсан байна.	- Шинэчлэлийн Засгийн газрын 11-11 төвөөр дамжуулан ирүүлсэн санал, хүсэлтэд хуулийн хугацаанд нь хариуг хүргүүлж ажиллаж байна.
	4/ Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтийн мэдээллийг яамны цахим хуудас / www.mofa.gov.mn /-аар дамжуулан нийтэд мэдээлэх.	Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлэсэн талаар цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлсэн байна.	- ҮХААЯ-нд ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн товч мэдээг цахим хуудаст www.mofa.gov.mn байршуулж байна. - Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын дагуу улирал бүр өргөдөл, гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлтийн мэдээг ЗГХЭГ-т хүргүүлэн ажиллаж байна. - 2014 оны 3 дугаар улирлын байдлаар яаманд бичгээр ирүүлсэн 147 өргөдөл, 11-11 төвд хандсан 454 санал хүсэлт, гомдол, яамны цахим хаягаар 87 санал, хүсэлт хүлээн авч, хариуг хүргүүлээд байна.

		<p>5/ Сайдад хаяглан шалгуулахаар шилжүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг өргөдөл гаргагчид мэдээлэх ба яамны цахим хуудас /www.mofa.gov.mn/-т тоон мэдээллээр тавьж мэдээлэх.</p>	<p>Сайдад хаяглан шалгуулахаар шилжүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг өргөдөл гаргагчид мэдээлж, яамны цахим хуудаст тоон мэдээллээр тавьж мэдээлсэн байна.</p>	<p>ҮХАА-н сайдад Завхан аймгийн иргэдээс ирүүлсэн 2014 оны 3 сарын 26-ны өргөдлийн дагуу тус яамны ЭБАТ Г.Наранцэцэг томилолтоор ажиллаж, Завхан аймгийн ҮХААГ-ын дарга Э.Балжинням нь хууль зөрчсөн гэж үзээд, “Хөрөнгө орлогын мэдүүлэг шалгуулах тухай” ҮХААЯ-ны 2014 оны 6 сарын 18-ны 01/2453 тоот албан бичгээр нотлох баримтын хамт АТГ-т шалгуулахаар хүргүүлсэн. АТГ-аас хариуг 2014 оны 05/6038 тоот албан бичгээр манай яаманд мэдэгдсэн. <i>/1 хуудас нотлох баримтыг хавсаргав./</i></p>		
		<p>6/ Ашиг сонирхлын зөрчлийн талаархи мэдээлэл, мэдэгдлийн дагуу шалгаж, хариуцлага тооцож ажиллах.</p>	<p>Ашиг сонирхлын зөрчлийн талаархи мэдээлэл, мэдэгдлийн дагуу шалгаж, хариуцлага тооцсон байна.</p>	<p>ҮХААЯ-ны албан хаагчдаас Ашиг сонирхлын зөрчлийн талаарх 189 удаагийн мэдэгдлийг хүлээн авч, бүртгэл хөтлөн ажиллаж байна. ҮХААЯ-ны 2 албан тушаалтан зөрчил үүссэн талаар мэдэгдсэн бөгөөд хууль тогтоомжийн дагуу дээд шатны албан тушаалтанд хандаж шийдвэрлүүлсэн. Зөрчил үүссэн талаар иргэд, аж ахуйн нэгжээс гомдол, мэдээлэл ирүүлээгүй. <i>/1 хуудас нотлох баримтыг хавсаргав./</i></p>		
17.	<p>Авлигын эрсдэл ба авилга гарах боломжийг бууруулах</p>	<p>1/ Авилгад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах.</p>	<p>Авилгад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргаж батлуулсан байна.</p>	<p>Хариуцан хэрэгжүүлж байгаа ажил, үүргийг харгалзан авилгад өртөх эрсдэлтэй албан хаагчдын судалгааг гаргаж, ТНБД-аар баталгаажуулсан. Дор дурдсан ажил хийж байгаа албан хаагчдыг эрсдэлтэй гэж үзлээ. Үүнд: - Яамнаас зохион байгуулж байгаа тендер, төсөл сонгон шалгаруулалт, гэрээ байгуулахад оролцож байгаа албан хаагчид, - Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулж жил бүр тодорхой хэмжээний санхүүжилтийг тусгадаг тул үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулдаг албан хаагчид - Аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олгодог албан хаагчид, - Санхүүгийн гүйлгээнд 2-р гарын үсэг зурах</p>	0-3	3

			эрхтэй нягтлан бодогч нар. <i>/Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэхэд шаардагдах баримт бичгийн 33-рт 3 хуудас нотлох баримтыг хавсаргасан./</i>		
	2/ Эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан, ажилтны үйл ажиллагааг хянах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор үйл ажиллагааг ил тод нээлттэй ажиллах шаардлага тавьж, гомдол, мэдээлэл ирсэн тохиолдолд тухай бүр арга хэмжээг авч ажиллах.	Эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан, ажилтаны үйл ажиллагааг хянах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.	Зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж дор дурдсан арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд: - Яамны цахим www.mofa.gov.mn хуудаст “Ил тод байдал” булан нээж санхүүгийн төлөвлөгөө, гүйцэтгэл, Тендер шалгаруулалтын урилга, мэдээ, Хяналт, шинжилгээний дүнг байршуулж, иргэдэд ил тод мэдээлж байна. Мөн яамны 6-р давхарт дэлгэц байршуулж, санхүүгийн гүйцэтгэлийн мэдээг тухай бүр мэдээлж байна. - ҮХААЯ-наас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр тогтмол сурталчилж байна. - Боловсруулж байгаа бодлогын баримт бичгийг ил тод нээлттэй хэлэлцүүлж, санал асуулга авч, зөв зүйтэй саналыг тусган ажиллаж байна. - 2014 онд зохион байгуулсан Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүн тус бүрт тухайн ТББ, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулж байна. - 2014 онд Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах зорилгоор АТГ-тай хамтран ҮХААЯ-ны албан хаагчдын дунд 3 удаагийн сургалтыг зохион байгуулав. - Яамны цахим www.mofa.gov.mn хуудаст “Авлигын эсрэг үйл ажиллагаа, ХАСХОМ” булан нээж, байрны 1-р давхарт мэдээллийн самбар ажиллуулж, Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, тендер, төсөл сонгон шалгаруулалт, яамнаас зохион байгуулах арга хэмжээний урилга зэргийг тогтмол байршуулж иргэдэд хүргэж байна. Мөн “Санал хүсэлтийн хайрцаг” ажиллуулж байна. - Тендер, төсөл сонгон шалгаруулах ажлын		

				<p>хэсэгт оролцож байгаа албан хаагчид болон ТББ, холбоодын төлөөллөөс ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдэгдлийг тухай бүр гаргуулж, 2014 онд нийт 189 удаагийн мэдэгдэл хүлээн аваад байна.</p> <p>- Яамны дотоод сүлжээнд сайд, ТНБД-ын тушаалын цахим мэдээллийн санг үүсгэн үйлчилж байна.</p> <p>ҮХААЯ-ны албан хаагчдын талаар гомдол одоогоор ирээгүй байна.</p> <p><i>/Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэхэд шаардагдах баримт бичгийн 34-рт 81 хуудас нотлох зарим баримтыг хавсаргасан./</i></p>		
		<p>3/ Авлигын эрсдэл ба авилга гарах боломжийг бууруулах зорилгоор худалдан авах ажиллагаа болон төсөл сонгон шалгаруулалтад ТББ, мэргэжлийн холбоодын төлөөлөлийг оролцуулах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх.</p>	<p>Авлигын эрсдэл ба авилга гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.</p>	<p>- Тендер, төсөл сонгон шалгаруулалт, хуулийн болон бодлогын баримт бичиг боловсруулахад ТББ, Мэргэжлийн холбоод, шинжлэх ухааны байгууллагуудын төлөөллийг оролцуулж хамтран ажиллаж байна.</p> <p>- Төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай, хүнд сурталгүй хүргэх зорилтыг дэвшүүлж, ёс зүй, харьцаа хандлагын зөрчил гаргасан, иргэдээс энэ асуудлаар гомдол ирсэн төрийн захиргааны албан хаагчийн Үр дүнгийн гэрээний оноог бууруулах нөхцлийг гэрээнд тусгаж өгсөн.</p> <p><i>/Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэхэд шаардагдах баримт бичгийн 16-рт 13 хуудас нотлох зарим баримтыг хавсаргасан./</i></p>		
18.	<p>Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар Авлигатай тэмцэх газарт мэдээлэх</p>	<p>1/ Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд Авлигатай тэмцэх газарт шалгуулахаар мэдээлэх.</p>	<p>Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд Авлигатай тэмцэх газарт шалгуулахаар мэдээлсэн байна.</p>	<p>Одоогийн байдлаар зөрчил илрээгүй байна.</p>	0-2	2

		2/ АТГ-аас хийсэн шалгалтын явцад зөрчил илэрсэн тохиолдолд мэдээлээгүй буруутай этгээдэд холбогдох хариуцлага хүлээлгэх.	АТГ-аас хийсэн шалгалтын явцад зөрчил илэрсэн тохиолдолд мэдээлээгүй буруутай этгээдэд холбогдох хариуцлага хүлээлгэсэн байна.	Одоогийн байдлаар зөрчил илрээгүй байна.		
19.	Төрийн байгууллагын байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглоно.	1/ Төрийн байгууллагын байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлуулахгүй байх арга хэмжээ авч ажиллах.	Төрийн байгууллагын байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлаагүй, арга хэмжээ авсан байна.	ҮХААЯ байрлаж буй Засгийн газрын 9А байранд тус яамны харьяа байгууллага болох Малын удмын сангийн үндэсний төв үйл ажиллагаагаа явуулж байна. Өөр байгууллага байрладаггүй.	0-1	1
20.	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх.	1/ Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг дотоод мэдээллийн “ASU” сүлжээнд байршуулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх.	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.	Авлигатай тэмцэх газраас 2014 онд ирүүлсэн албан бичгийн биелэлтийг тухай бүр заасан хугацаанд хүргүүлж ажилласан.	0-5	5
		2/ АТГ-аас ирүүлсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах мэдэгдэл болон зөрчил арилгуулах, хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулах тухай албан бичгийн дагуу хэрэгжилтийг зохион байгуулах.	Мэдэгдэл, албан бичгийн дагуу арга хэмжээг авсан байна.	Одоогоор ийм нөхцөл байдал үүсээгүй байна.		
		3/ АТГ-аас авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн байгууллагын дотоод үйл ажиллагаанд болон нийтээрээ дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгох.	Тухай бүр тодорхой арга хэмжээг авч ажилласан байна.	Одоогоор ийм нөхцөл байдал үүсээгүй байна.		

		4/ АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаархи мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг биелүүлэх.	Журмын дагуу арга хэмжээг авч ажилласан байна.	Одоогоор ийм нөхцөл байдал үүсээгүй байна.		
2. Авилгатай тэмцэх санал, санаачлага						
21.	Байгууллагын удирдлагын авилгатай тэмцэх хүсэл, эрмэлзлэл	1/ Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилгыг /уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/-д дэмжиж, нэгдэж ажиллах.	Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилга, уриалгад нэгдэж ажилласан байна.	АТГ-аас санаачлан “ЭБАТ” facebook групп нээж, бүх байгууллагуудын ЭБАТ-уудын үйл ажиллагааг сурталчлах, санал солилцох боломж олгосон нь бид ажил үүргээ түргэн шуурхай, хүндрэлгүй явуулахад их дэмжлэг болж байна. Энэхүү цахим хуудсаар дамжуулан ЦЕГ, НДЕГ-аас гаргасан уриалгыг хүлээн авч, дэмжиж, өөрийн байгууллагын самбарт байршуулж сурталчилсан. <i>/2 хуудас нотлох баримтыг хавсаргав./</i>	0-15	15
		2/ Авлигын эсрэг арга хэмжээнд тодорхой хөрөнгө гаргаж, санхүүжүүлэх	Авлигын эсрэг арга хэмжээг санхүүжилсэн байна.	2014 онд 1,850,000 төгрөг тусгагдсан бөгөөд зардлыг хэмнэж, аливаа зөвлөмж, зөвлөгөөг биечлэн өгч, гарын авлага, хууль таниулах сурталчилгааг яамны дотоод цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах замаар хүргэж байгаа бөгөөд одоогоор зарцуулаагүй байна.		
		3/ Удирдах албан тушаалтнууд авилгатай тэмцэх хүсэл, эрмэлзлэл, хүчин чармайлт, үлгэр жишээ, санаачлага гаргаж ажиллах.	АТГ-аас тусгайлан боловсруулсан санал асуулгаар үнэлүүлж, үр дүн өмнөх оныхоос сайжирсан байна.	-Тус яамны удирдах албан тушаалтнууд тендер, төсөл сонгон шалгаруулалтад оролцох бүрт ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг цаг тухайд нь манлайлан гаргаж өгч байна. - Долоо хоног бүр удирдлагын шуурхай хурал зохион байгуулж, хийсэн ажил, удаашралтай байгаа ажлуудын талаар ярилцаж, санал солилцож, үүрэг даалгавар өгч, биелэлтийг 7 хоног тутам тооцож ажиллаж байна. - ТНБД-ын санаачлагаар шийдвэр гаргаж, албан хаагчдын дунд сар бүр “Мэдээллийн		

				цаг” зохион байгуулж, үйл ажиллагааны талаар танилцуулга, зөвлөмж, зөвлөгөө, мэдээлэл өгч албан хаагчидтай санал солилцож байна. Байгууллагын удирдлагуудын зүгээс авилгатай тэмцэх хүсэл, эрмэлзлэлтэй ажилласны үр дүнд 2014 онд гомдол ирээгүй, зөрчил илрээгүй ажиллаж байна.		
22.	Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх	1/ Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах.	Ёс зүй, сонирхлын зөрчлийн талаар сургалт, өдөрлөг зохион байгуулж, зөвлөмж өгч ажилласан байна.	- АТГ-аас 2014 оны 01 дүгээр сарын 09-нд ҮХААЯ-ны албан хаагчдын дунд зохион байгуулсан ”ХАСХОМ мэдүүлэгч нарт зориулсан сургалт”, - АТГ, “Нийгмийн дэвшлийн эмэгтэйчүүд” хөдөлгөөнтэй хамтран 02 дугаар сарын 07-ны өдөр ҮХААЯ-ны албан хаагчдын дунд зохион байгуулсан “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах” сургалт - АТГ-аас 2014 оны 04 сарын 24-нд зохион байгуулсан “ЭБАТ-тай ярилцах цаг” сургалт, - АТГ-аас 2014 оны 10 сарын 31-ний өдөр ҮХААЯ-ны албан хаагчдын дунд зохион байгуулсан “Авлигын эсрэг хууль таниулах” сургалтад тус тус хамрагдлаа.	0-15	15
		2/ Байгууллагын дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээгээр илрүүлсэн авлигын зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллах.	Илрүүлсэн авлигын зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан байна.	ҮХААЯ-ны хүний нөөцийн асуудалд хийсэн дотоод аудитын зөвлөмжийн дагуу дор дурдсан ажлуудыг хэрэгжүүлээд байна. - ТНБД-ын 2014 оны Б/121 тоот тушаалаар Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн албан хаагчдын орон тоог цомхотгож, шинэчлэн баталсантай холбогдуулан 7 албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулж батлуулсан. - Төрийн албан хаагчдын 2014 онд байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг хагас жилээр дүгнэж, үүргээ хангалтгүй биелүүлсэн 3 албан хаагчдад ТНБД-ын 2014 оны Б/109, 121 тоот тушаалаар сахилгын шийтгэл ноогдуулав. - Мэдээллийн цаг зохион байгуулах тухай ТНБД-ын 2014 оны А/384 тоот тушаалыг гаргаж, эхний мэдээллийг СБТГ-аас 10 сарын	+10	

				31-ний өдөр амжилттай зохион байгуулав. <i>/Энэхүү төлөвлөгөөний 5.3 дахь заалтад 8 хуудас нотлох баримтыг хавсаргав./</i>		
		3/ Бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчлийн дагуу арга хэмжээ авч ажиллах.	Илэрсэн зөрчлийн дагуу арга хэмжээ авч ажилласан байна.	Одоогоор ийм нөхцөл байдал үүсээгүй байна.	-5	
		4/ Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг ба бусад зөрчлийг гаргуулахгүй, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах.	Илэрсэн авлигын гэмт хэрэг ба бусад зөрчлийг гаргуулахгүй, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан байна.	Одоогоор ийм нөхцөл байдал үүсээгүй байна.	-5	
	ДҮН				100	99

.....оОо.....